

Батлав.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын Дарга

Ц.Уранчимэг

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Эрчим ХХК-ийн
Ерөнхий захирал

М.Тилеуберди

**УВС АЙМГИЙН БӨХМӨРӨН СУМЫН
НҮҮРСТ ХОТГОР 1-Р ДАВХАРГА
УУРХАЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-005696 /

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2003821/

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын ахлах шинжээч

Ц.Жаргалнэмэх

Боловсруулсан:

Эрчим ХХК-ийн
Байгаль орчны ажилтан

Д.Батзул

Агуулга

1.1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.2. Ордын товч танилцуулга	2
1.3. Төслийн хүчин чадал	4
1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө	6
1.5. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	6
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
2.1. Байгаль орчин	7
2.2. Нийгэм Эдийн Засаг	7
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	9
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
6.1 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН	14
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Компанийн товч танилцуулга

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших Нүүрст хотгорын нүүрсний ордын талбайгаас “Давхарга-1” нэртэй 29га лицензийн талбайг бүртгэлийн 211001067 тоот гэрчилгээтэй “Рысжан”ХК-д 30 жилийн хугацаатай олгож 2009 оны 04 сарын 03-ний өдрийн ГУУКХ-ийн даргын 39 тоот шийдвэрээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг 210001004 тоот гэрчилгээтэй “Эрчим Баян-Өлгий” ХК-д шилжүүлсэн болно.

1.2. Ордын товч танилцуулга

Ордын нөөц Нүүрст хотгорын ордын 1-р давхарга нь налуу байрлалтай нэгэн цул биетээс бүрддэг бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн хил дотор байгаа хэсгийн урт нь -570 м, өргөн нь -250 м юм. Нүүрсний давхаргын хүрээлэл: Нүүрст хотгорын нүүрсний ордын 1-р давхаргын хайгуулын явцад цуглуулсан судалгааны материалууд, хийсэн ажиглалтууд, уул-өрөмдлөгийн ажлын үр дүн, хайгуулын талбай дахь нүүрсний давхарга нь тодорхой зүй тогтолтой, геологийн тод хил заагтай гэдгийг тогтоосон. Нүүрсний давхаргын хүрээллийг тогтоох, нөөцийн тооцоо хийхэд дараах жишгийн үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

- Нөөц тооцоолох нүүрсний үеийн хамгийн бага зузаан 2.0м
- Нүүрсний бохирдолтод орох нүүрсэн дахь чулууны үеийн хамгийн их зузаан 1.0 м
- Бохирдолт тооцсон нүүрсний үеийн хамгийн их үнслэг 40%

Бодиттой нөөцийн (B-I, B-II) хил заагийг 220-250 х 100-150-ын тороор судалсан хэсгээр зааглаж, харин нүүрсний давхарга нь хойд болон урд талын зах тийшээ тусгай зөвшөөрлийн талбайн хил дотор тасралтгүй үргэлжилж байгаа нь батлагдаж байгаа тул хайгуулын шугамууд ба цооногуудаас тусгай зөвшөөрөлтэй талбай хил хүртэл боломжтой (B-III, B-IV) нөөцийн хил заагийг хязгаарласан.Нөөцийн тооцооны аргачлал: Нүүрсний давхаргыг параллель байрласан хайгуулын шугамаар босоо цооногийн системээр судалсан тул нөөц бодоход “Геологийн зүсэлтийн арга”-ыг сонгож авсан байна. Энэ ажлын хүрээнд ордын хэмжээнд 3 шугамаар 3 геологи-литологийн зүсэлт хийж ордын нөөцийн тооцоог үйлджээ. Нөөц бодох явцад дараах үзүүлэлтүүдийг тодорхойлов. Үүнд:

Геологи-литологийн зүсэлт дах нүүрсний давхаргын талбайг хэмжих, тодорхойлох

Нүүрсний давхаргын техникийн шинж чанарын дундаж үзүүлэлтүүдийг цооног хайгуулын шугам тус бүрээр болон давхаргын хэмжээнд тодорхойлох

Нүүрсний давхаргын эзлэхүүнийг тодорхойлох

Нүүрсний давхаргын нөөцийг тодорхойлох зэрэг болно.

Нөөцийн блок В-1:

Нөөцийн В-1 блок нь хайгуулын II-II¹, III-III¹ шугамуудын хооронд орших ба тэдгээр шугамууд дээр өрөмдсөн хайгуулын цооног Ц-1, Ц-3, Ц-5, Ц-6, уурхайн, III-I, III-2 хамрагдах ба II-II¹ зүсэлтийн талбай 16428 м², III-III¹ зүсэлтийн талбай 13750 м², зүсэлтүүдийн хоорондох зай 250 м. Блокийн нийт эзлэхүүнийг $V=L/2 (S_1+S_2)$ томъёогоор тооцоолон гаргасан ба нүүрсний эзлэхүүний жин 1.38 тн/м³, блокийн нөөцийг 5205.7 мян.тн гэж тогтоов. Энэ хэсгээс өмнөх онуудад нийтдээ / 2009-2013 онуудад/ 72.0 мян.тн нүүрс олборлож ашигласан болно. Одоо үлдсэн нөөц нь 5133.7 мян.тн юм.

Нөөцийн блок В-2:

Энэ блокийн талбайд I-I ба II- II шугамуудад байрладаг Ц-1, Ц-3, Ц-2, Ц-4, цооногууд ба III-3 хамрагдана. II- II зүсэлтийн талбай 16428 м², I-I зүсэлтийн талбай 9055 м², зүсэлт хоорондын зай 220 м, блокийн эзлэхүүн ($V=\frac{S_1+S_2+\sqrt{S_1+S_2}}{3} \times L$) томъёогоор 2763166 м³, блокийн нүүрсний нөөцийг 3813.2 мян.тн гэж тогтоов. Эзлэхүүний жин 1.38 тн/м³.

Нөөцийн блок В-3:

Энэ блокт III-III шугамд орших цооногууд ба шурфын (Ц-6, Ц-5, III-1,2) үр дүн, энэ шугамын хойд талд тусгай зөвшөөрлийн талбай хойд хил хүртэлх зайд байрладаг нүүрсний давхаргын хэсэгт хамрагдах ба III-III зүсэлтийн талбай 13750 м², хойт хилээр хязгаарлагдсан хэсгийн талбай 13084 м² ба блокийн эзлэхүүн нь $V= L / 2 (S_1 + S_2)$ томъёогоор тооцоолоход 402510 м³, хоорондох зай 30 м, эзлэхүүний жин 1.38 тн/м³, нөөц нь 555.5 мян.тн байна.

Нөөцийн блок В-4:

Нөөцийн В-4 блок нь хайгуулын I-I шугамаас урагшаа тусгай зөвшөөрлийн талбайн урд хил хүртэл орших ба энэ шугамд өрөмдсөн Ц-2, Ц-4 цооногууд ба шурф III-3-ын үр дүн хамрагдана.

I-I шугамын зүсэлтийн талбайн 9055 м², тусгай зөвшөөрөлтэй талбайн хилээр хязгаарлагдсан хэсгийн талбай 8137 м² ба хоорондын зай 74м, блокийн эзлэхүүн 636104 м³ байна. Томъёогоор тооцоолон 877.8 мян тн-оор тогтоов. Эзлэхүүний жин 1.38 тн/м³ байна.Нүүрстхотгорын нүүрсний ордын 1-р давхаргын нийт бодитой нөөц нь В+С 10380.2 мян.тн болно.

#	Нөөцийн зэрэглэл	Блокийн дугаар	Блок хамрагдсан зүсэлтүүдийн дугаар	Огтлолуудын талбай, м ²	Шугамын хоорондын зай	Давхаргын эзлэхүүн, м ³	Эзлэхүүн жин тн/ м ³	Нүүрсний нөөц, мян.тн
1	Бодитой	В-1	II-II	16428	250	3772250	1.38	5205.7
2			III-III	13750				
3		В-2	II-II	16428	220	2763166	1.38	3813.2

4	Нөөц /В/	C-1	I-I	9055	30	402510	1.38	555.5
5			III-III	13750				
6			III-III-2	13084				
7		C-2	I-I	9055	74	636104	1.38	877
8			I-I-I	8137				
Нийт бодит /В/ нөөц								10452.2

Төслийн байршил “Эрчим Баян-Өлгий” ХК-ийн эзэмшиж буй MV-005696 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Нүүрст хотгор 1-р давхарга” нэртэй талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 1700 км, Увс аймгийн төв Улаангом сумаас баруун хойш 130 км, Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос зүүн хойшоо 131 км, Бөхмөрөн сумын төвөөс зүүн хойшоо 60 км, Хотгорын нүүрсний уурхайгаас баруун тийш 7 км-ийн зайд оршдог.

Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Олгосон огноо	Аймаг, сум
Нүүрст Хотгор 1-р давхрага	005696А	2009-04-03	Увс, Бөхмөрөн

Газар зүйн солбицол : Л-46-11

- | | | |
|----|--------------|--------------|
| 1. | 90°47'56,21" | 49°49'52,97" |
| 2. | 90°47'31,22" | 49°49'52,97" |
| 3. | 90°47'31,22" | 49°49'11,77" |
| 4. | 90°47'56,21" | 49°49'11,77" |



Тусгай зөвшөөрлийн
талбайн байршил

1.3. Төслийн хүчин чадал

“Эрчим Баян-Өлгий” ХК-ийн нүүрсний уурхайн жилд 70000 тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Тус уурхайн Баян-Өлгий аймгийн төвийн Дулааны станц, Өлгий хот, Бөхмөрөн сумын оршин суугч айл өрхүүдийн нүүрсний хэрэглээг хангах зорилгоор нүүрс олборлох, борлуулах үйл ажиллагааг явуулдаг.

Тус компани ТЭЗҮ-д заасны дагуу 2026 онд 55000 м3 хөрс хуулж, 65000 тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй байна. 2026 онд 1260 сая/төгрөгийн борлуулалтын

ажил хийж, улсын ба орон нутгийн төсөвт 217.41 сая/төгрөгийн орлого оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Эрчим Баян-өлгий” ХК нь Ашигт малтмалын газрын Нүүрсний хэлтсээр батлуулсан 2026 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулна. Тус компанийн үйл ажиллагаа 16 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа. Одоогийн байдлаар Техник Эдийн Засгийн Үнэлгээг 2024 онд шинээр батлуулсан.

#	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг
1	DAEWOO-280	0.8-1 м³	1
2	Ачигч ZL 30	3 м³	1
3	HITACHI 210W	1.3 м³	1
4	Бульдозер	2.5 м³	1
5	Усны тэрэг, Зил 130	5 тн	1
6	Суудлын машин	5 хүн	1
7	HITACHI 330W	1,0-1,2 м³	1
8	Автосамсомал	25 тн	3

Ажиллах хүчний мэдээлэл

#	Албан тушаал	Орон тоо
Инженер техникийн ажилтан		4
1	Уурхайн дарга	1
2	Ерөнхий инженер, Маркшейдер	1
3	Ашиглалтын инженер	1
4	Байгаль орчны ажилтан	1
Үйлдвэрийн хэсэг		
1	Экскаваторын оператор	2
2	Автосамосвалын жолооч	2
4	Гагнуурчин, цахилгаанчин	1
5	Бульдозерын оператор, жолооч	1
6	Засварчин	1
7	Ачигчийн оператор	1
8	Үйлчлэгч	1
9	Тогооч	1
10	Манаач	1
11	Галч	1
12	Хүнд механизмын жолооч	3
Нийт дүн		16

1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

Нүүрсний уурхайн гол гүйцэтгэх ажил нь хөрс хуулалтын ажил ба нүүрс олборлолтын ажил юм. Манай уурхай хойд талаараа уулархаг баруун талын гаршаас эхэлж зүүн тийшээ явуулж байгаад зүүн талын нүүрс шаргал чулуутай нүүрсний чанар муудсан тул 2026 оны төлөвлөгөөндөө карьерын урд талд төлөвлөж өгсөн болно.

2026 онд карьерын урд талаас 0.5га газар хөрс хуулж, 55000 м3 хөрс хуулахад 65000-75000 тн нүүрс олборлож хэрэглэх болно.

1.5. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, БОНБНУ-ний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн боловсруулсан ба агуулга болон холбогдох зардлыг доорх хүснэгтэд нэгтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл

#	Агуулга	Зардал, мян. төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3460.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1300.0
3	Дүйцүүлэн хамгаалалах арга хэмжээний төлөвлөгөө	4400.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	0.0
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	100.0
6	Химийн бодис	0.0
7	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1470.0
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1100.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1400.0
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1300.0
11	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	520.0
НИЙТ ЗАРДАЛ		15050.0

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин

Уур амьсгал Бөхмөрөн сумын орчим эх газрын уур амьсгалтай, хур тунадас их, жилд дунджаар 123 -144 мм, үүний 85 -95 хувь нь дулааны улиралд (IY–X сар) унадаг, хамгийн их тунадас 7дугаар сард унаж жилийн нийлбэрийн 30% орчим хүрнэ. Өвөл харьцангуй хүйтэн, дунджаар 4-30 мм тунадас унадаг. Агаарын жилийн дундаж температур –3.70C хүрч 1-р сарын дундаж температур –49.60C, 7-р сарынх +38.40C хүрнэ.

Ургамалжилт Төсөл хэрэгжих орчмын газар нутаг нь ургамалжилтын байдлаар Евразийн хээрийн мужийн Ачит нуурын хотгорын цөлийн хээрийн тойрогт хамаарагдана. Энд Элдэв өвс-Үетэнд, Хялганат, Элдэв өвс-Улалж-Биелэг өвс-Үетэн, Агь-Хялганат, Ботуул-Агьд бүлгэм жилтэй бөгөөд *Stipa krylovii*, *Cleristogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Carex duriuscula*, *Allium bidintatum*, *Agenaria cappilaris** *Artemisia frigida* зэрэг олон төрөл зүйлийн ургамлын нөмрөгтэй. Уурхайн нь Ачит нуурын хотгорын зүүн хойд хэсэгт Байрамын нурууны өвөрт далайн түвшинээс 2050-2100 м-ийн өндөрт уулархаг бүсэд байрлах бөгөөд уулын хуурай хээрийн цайвар хүрэн хөрс зонхилон тархсанаараа онцлогтой.

2.2. Нийгэм Эдийн засаг

Бөхмөрөн сум нь хойд талаараа Оросын Холбооны улс, зүүн талаараа Сагил, Түргэн урд талаараа Ховд сум баруун талаараа Баянөлгий аймгийн Ногоон нуур сумтай тус тус хиллэдэг. Аймгийн төв Улаангом сумаас 260км алслагдсан 589 айл өрхтэй 2290 хүн амтай, 3 багтай Гурван жигэртэй, Байшинт, Хар алтат. Хүн амын гол хөдөлмөр мал аж ахуй хувиараа газар тариалан эрхлэн амьдардаг. Нүүдлийн мал аж ахуйтай.

Захиргаа, эмнэлэг, сургууль /8-11/, цэцэрлэг, харилцаа холбоо зэрэг улсын төсвийн байгууллагууд ажиллахаас гадна худалдаа үйлчилгээ, жижиг үйлдвэрлэл эрхэлдэг. Аймаг сумдын хооронд авто тээвэр, харилцаа холбоо сайн хөгжсөн. Өндөр хүчдэлийн сүлжээнд холбогдсон. Цаг уурын эрс тэрс уур амьсгалтай.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нүүрсний олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа тул тодорхой хэмжээгээр байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байна. Үүнд:

Агаар: Тус ордыг ашиглах явцад их хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан хүн ам, амьтан, ургамал, хөрс, усанд нөлөөлөхүйц хэмжээний агаарын бохирдол үүсэхгүй юм.

Харин агаарын бохирдолт нь хөрсний болон нүүрсний мөргөцгөөс үүссэн тоос, тэдгээрээс дагалдан гарах хорт элемент агуулсан хийн улмаас үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад тоос үүсгэж болох эх үүсвэр нь өрөмдлөг тэсэлгээний ажил, тээврийн хэрэгсэл, ухаж, ачих машинууд болно.

Түүнчлэн хөрсний овоолгыг бүрдүүлж байгаа чулуулгийн физик механикийн шинж чанар, тогтцод өөрчлөлт орох ба сийрэгжсэн хөрс овоолгод ачигдах тул төрөл бүрийн механик өгөршилд амархан орно.

Уурхайд ажиллаж байгаа дотоод шаталтын хөдөлгүүртэй машин механизмаас мөн тэсэлгээний ажлын улмаас нүүрстөрөгчийн исэл, хүхрийн исэл, азотын исэл, устөрөгч зэрэг хортой элемент агуулсан хий, хөө тортог агаарт дэгдэнэ. Эдгээр элементүүд нь агаарыг бохирдуулан хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй, хүний эрүүл мэнд, хэвийн ажиллах боломжийг алдагдуулах нөхцөл үүсгэж болзошгүй. Иймд уурхайн агаарын бохирдлыг байнга хянаж бохирдлын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд түүнийг бууруулах арга хэмжээг авна.

Хөрс: Одоогийн байдлаар уурхай орчмын хөрс олборлолт болон машин техникийн элэгдэлд орсон байна. Гэвч цаашдаа дахин олборлолтын явцад хөрс ухагдаж, газрын гүний хөрс өнгөн хэсэгт гарч, өнгөний хөрс дарагдах зэрэг нөлөөгөөр өнгөн хөрсний бохирдол, доройтол болох магадлал өндөр байна. .

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу 2026 онд уурхайн бүхий л үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдэлийг бууруулах зэрэгт чиглэгдсэн үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу явуулж, үр дүнд анализ хийнэ. Мөн мэргэжлийн байгууллагаар тогтсон хугацаанд хөндлөнгийн хяналтыг хийлгэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн хүрээнд 200 модыг тарихаар төлөвлөлөө.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлыг 15,050,000 /Арван таван сая мянга/ төгрөг байхаар төсөвлөсөн бөгөөд үүний 50 хувийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, “Ашигт малтмалын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс” буюу Төрийн сангийн дансанд байршуулна.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Агаарын чанар, цаг уурын нөхцөл

#	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хийн хаягдлаар агаар бохирдох	Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, үзлэг оношилгоонд хамруулах	Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбай	ш	50.0	7	350.0	Үйл ажиллагааны туршид	MNS 50136:2003 MNS 5014:2003 Агаарын тухай хууль БОНБУ
2	Орчны тоосжилт үүсэх	Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах		га	Үйл ажиллагааны зардалд тусгав	10	Үйл ажиллагааны зардалд тусгав	Дулааны улиралд тогтмол	
3	Дуу шуугианы бохирдол үүсэх	Машин механизм тоног төхөөрөмжөөс үүсэж буй дуу шуугианыг багасгах үүднээс хуучирсан тоног төхөөрөмжийг ашиглахгүй байх, засварлах, шинэчлэх		ш	30.0	7	210.0	Үйл ажиллагааны туршид	
							560.0		
Дэд дүн							560.0		

2. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлий									
#	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Уурхайн талбайд шимт хөрсийг тухайн талбайг нөхөн сэргээхэд буцааж ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгалах	Газар хөндөлт хийх хэмжээгээр	м³	Уулын ажлын төсөвт багтсан	Уулын ажлын төсөвт багтсан		Тайлант хугацаанд	БОНБНУ
5		Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргуулахгүй байх	Уурхайн дотоод замууд	ш	50.0	10	500.0		
6	Хөрсний чанар доройтох	Хөрсний шинжилгээний дүнгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж гадаад овоолгын талбайд хаях	Уурхайн нийт талбай	Хян алт ын цэг	100.0	2	Төлөвлөгөөний хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан	Тухай бүрт	
7	Хөрсөнд бохирдол үүсэх	Хогийн сав, хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх	Уурхайн талбай	ш	200.0	3	600.0	Тогтмол	
8	Уурхайн болон ажилчдын хотхоны ургамалан бүрхэвч доройтох	Мод бут тарьж зүлэгжүүлэх, тарьсан модоо арчлах	Уурхайн талбай	га	750.0	0,5	750.0	3 дугаар улирал	
Дэд дүн							1,850.0		

*** Дээрх төлөвлөгөөнд байгууллагын үйл ажиллагааны тогтмол зардалд ордог зардлуудыг тусгаагүй болно.

3. Гадаргын ба газрын доорх усны нөөц

#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9	Төрийн байгууллагаар ус ашиглах дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авч гэрээ байгуулах,	Уурхайн ус ашиглалттай холбоотой бүхий л асуудлууд	төг	920.0	1	920.0	1-р улиралд	Усны тухай хууль
10	Усны чанарын шинжилгээг тогтмол хийлгэх		төг	65.0	2	130.0	5, 9 сар	
11	Ус ашигласны төлбөрийг төлөх		Үйл ажиллагааны төсөвт багтсан					Усны тухай хуулийн 28.6, 29.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хууль
Дэд дүн						1,050.0		

4.Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөөллийг бууруулах

#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
12	Үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээрт махчин шувууны үүрнүүд байршуулах	Төслийн талбайн ойролцоох бэлчээр нутагт	ш	ОХШХ-т тусгав	1	ОХШХ-т тусгав	9-р сар	Амьтны тухай хууль
НИЙТ ДҮН						3,460.0		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүрсний гүн 53 метрээс дээш байна. Карьерийн гүн 21 метрт хүрч байна. Доошоогоо 35 м нүүрс байна. Тийм учраас биологийн нөхөн сэргээлт хийх ажил төлөвлөгдөхгүй. Бөхмөрөн сумын нутагт хэрэгждэг “Нэг зам” төслийн хүрээнд сумын засаг захиргаатай хамтран тогтоосон байршилд үүссэн олон салаа замыг хаах, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Төслийн талбайн эргэн тойронд	Үйл ажиллагааны төсөвт багтсан			3-р улирал	MNS 5917:2008

6.1 “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд 2026 онд 200ш улиасыг тусгай зөвшөөрлийн талбай дахь /нүүрсний нөөцийн хэсэгт үл хамаарах/ газар гуу жалга сайрд тарихаар төлөвлөж байна. Мод тарих услах зардлыг нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагааны зардлаас зарцуулах болно.

#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Мод тарих	Уурхайн талбай	6.5	200	1,300.0	Мод тарилтын үед	Мод тарих агротехник, БОАЖ Сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал 2021.07.09 А/172, 116
НИЙТ ДҮН						1,300.0	

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Зэрлэг ан амьтны бэлчээр газар хужир шүү, өвс тавьж өгөх	Төслийн талбайн эргэн тойронд	4,400.0	1 удаа	4,400.0	3 болон 4 дүгээр улиралд	БОНБУ
НИЙТ ДҮН					4,400.0		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхайн орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд 2 ширхэг хөшөө чулуу, 6 хиргисүүрүүд байдаг. Энд байгаа хөшөө чулуу хиргисүүрүүдийг хашаалан хамгаалалтад авсан.

2011 оны 10 дугаар сарын 25-нд Улаанбаатараас Ш.У.А-ийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, Соёлын өвийн хяналтын улсын байцаагч, доктор дээд профессор Ц.Төрбатаар судалгаа хийлгэж, улсын тооллогод бүртгүүлсэн болно.

2021 онд уурхайн урьд талын ирмэгт тэлэлт хийхийн тулд $x=5522450$ $y=341515$ координаттай хиргисүүрүүдийг ШУА-ийн Археологийн хүрээлэнд хүсэлт гаргаж гэрээ хийсэн тул аврах малталт хийлгэсэн.

2026 онд хөшөө чулуу хиргисүүрийн хашаа хамгаалалтыг сэргээж, засварлана.

#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөшөө чулуу, хиргисүүрүүдийн хашааг засварлах	Уурхайн талбай	50.0	2	100.0	7 сард	Соёлын өвийн тухай хууль
НИЙТ ДҮН						100.0	

*** Урьдчилан төсөвлөх боломжгүй зардлын төрөлд хамаарна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол зорилт Уурхайн үйл ажиллагааны явцад технологийн үйл ажиллагаанаас үүдэн ус нэвчих, гал түймэр гарах зэрэг эрсдэл гарах болзошгүй тул осол, эрсдлийг урьдчилан тооцох, дотоод хяналтыг байнга тавих, ослын үед яаралттай арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай материал болон авран хамгаалах хэрэгслийн нөөцийг хангаж, ажиллагсад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт явуулан, үйл ажиллагаанд дотоод хяналт тавина.

#	Болзошгүй аюул, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Ашиглалтын үеийн болзошгүй аюул, ослыг бууруулах	1	Ажилчдыг ажлын хувцасаар хангах	тогтмол	10	90.0	1,300.0	Тайлант онд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
		2	Ажилчдыг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах. Тогтмол олгох			250.0			
		3	Болзошгүй аваар ослын үед яаралттай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах			150.0			
		4	Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах сургалт зохион байгуулах	Жилд 1 удаа	500.0	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал			
			Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, сургалт явуулах						
			Хөдөлмөр хамгааллын дотоод журам боловсруулах, сургалт явуулах						
			Машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглах журам боловсруулах, сургалт явуулах						
		5	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах. Эрүүл ахуйн сургалт зохион байгуулах		170.0	Үйл ажиллагааны зардалд			
		НИЙТ ДҮН					1,470.0		

*** Урьдчилан төсөвлөх боломжгүй зардлын төрөлд хамаарна.

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол зорилт Төслийн үйл ажиллагааны туршид хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, төслийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад оршино.

Хүрэх үр дүн Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлаас орчны агаар, ус, хөрсийг бохирдуулж болзошгүй учраас хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, зохих арга хэмжээг авч сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу зохицуулалтыг хийх, энгийн хог хаягдлын хэмжээг багасгаж, орон нутгийн нэгдсэн хогийн цэгийн ашиглалтын хугацааг уртасгах зэрэг юм.

Хийх ажил Сумын төвлөрсөн хог хаягдлын цэгт 6, 12 сард 20 тонны машинаар ачиж буулгана. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байранд хадгалж мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хүргүүлнэ Төмрийн хаягдал, аккумулятор, резин, дугуй гэх мэтийн хаягдлуудыг ялгаж хоёрдогч түүхий эдэд тушаана.

#	Хог хаягдлын ангилал Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ, эх үүсвэр	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ /жилээр/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
1	Хог хаягдлын бүртгэл хөтлөх: - Аюултай хог хаягдал - Энгийн ахуйн - 2догч түүхий эд	Уурхайн үйл ажиллагаа	тн	Үйл ажиллагааны зардалд тусгав	2	Үйл ажиллагааны зардалд тусгав	Жилийн туршид	Хог хаягдлын тухай хууль
2	Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах		тн					
3	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх		төг	500.0	1	500.0		
4	Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалж тогтмол хугацаанд ачиж буулгах		тн	300.0	2	600.0		
4	Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийн байгаль хамгаалагчийг цалинжуулах		төг	1,000.0	12 сар	Уурхайн төсөв	Хөдөлмөрийн тухай хууль	
НИЙТ ДҮН						1,100.0		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

1. Агаар орчны мониторинг							
#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
1.1	<u>Тоосжилт</u> Нийт тоос, PM10, PM2.5	Хяналтын цэгүүдэд	5, 9 сар	2	100.0	200.0	MNS4585:2016 Агаарын чанар, зөөврийн багажаар зааврын дагуу дээж авах
1.2	<u>Агаар бохирдуулагч хий</u> - SO ₂ Хүхэрлэг хий - NO ₂ Азотын давхар исэл	Хяналтын цэгүүдэд	5, 9 сар	2	100.0	200.0	MNS4585:2016 Агаарын чанар, Зөөврийн багажаар зааврын дагуу хэмжих, дээж авах
Дэд дүн						400.0	
2. Усан орчны мониторинг							
#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
2.1	Химийн шинжилгээ	Худгийн ус	5, 9 сар	2 удаа	200.0	400.0	MNS 6148:2010 “Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Дэд дүн						400.0	
3. Хөрсний мониторинг							
	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
3.1	Хөрсний шинжилгээ	Хяналтын цэгүүдэд	5, 9 сар	2 удаа	200.0	400.0	MNS 3310:1991
Дэд дүн						400.0	

4. Амьтны аймаг							
	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян.төг/	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах стандарт, арга аргачлал
4.1	Үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээрт махчин шувууны үүрнүүд байршуулах	Төслийн талбайн ойролцоох бэлчээр нутагт	9-р сар	2	100.0	200.0	Амьтны тухай хууль
Дэд дүн						200.0	
НИЙТ ДҮН						1,400.0	

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

#	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
БОМТ-ний хэрэгжилтийн явцын хяналт				
1	Ус, хог хаягдал, орчны шинжилгээнүүдийн гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай хийж ажиллах.	Үйл ажиллагааны төсөв	1-3 сар	Байгаль орчны ажилтан, уурхайн дарга
2	Цаг үеийн байдал орон нутагт хүндэрсэн тохиолдолд аймаг, сум, багийн удирдлага иргэдтэй хамтран ажиллах	Үйл ажиллагааны төсөв	Жилийн туршид	
3	Уурхайн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны төсөв	2 дугаар улиралд	
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах	600.0	Тайлант онд	
5	Түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал түймрийг унтраах багаж хэрэгсэлийг бэлтгэн байнгын бэлэн байдалд байлгах	100.0	5-10 сар	
6	Аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар тайлбарлаж таниулах сургалт зохион байгуулах	500.0	6,9 сар	
7	Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, сургалт явуулах			
8	Хөдөлмөр хамгааллын дотоод журам боловсруулах, сургалт явуулах			
9	Машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглах журам боловсруулах, сургалт явуулах			
10	Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг 1 удаа орон нутгийн засаг захиргаанд тайлагнах, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээллэнэ.	100.0	4 дүгээр улиралд	
11	БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг Увс аймгийн БОАЖГазарт хүргүүлж дүгнүүлэх	Үйл ажиллагааны төсөв	2026.11.01	
12	БОАЖЯ-ХБОБНУГазарт дүгнүүлсэн тайланг дараа оны төлөвлөгөөний хамт хүргүүлэх	Үйл ажиллагааны төсөв	2026.12	
НИЙТ ДҮН		1,300.0		

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

#	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Тайлагнах							
1	Бөхмөрөн сумын ЗДТГазар	Жилийн тайланг боловсруулан хүргүүлэх	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлан	2026 оны 11-р сарын 01-ний дотор	520.0	Уурхайн дарга, Байгаль орчны ажилтан	БОГ
2	Увс аймгийн БОАЖГазар	Батлагдсан тайлангийн хувийг хүргүүлэх	Төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан	БОУАӨЯ-аар хянагдан гарсан үед		Уурхайн дарга, Байгаль орчны ажилтан	
3	ХБОБНУГазар	Батлагдсан тайлангийн хувийг хүргүүлэх	Төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан	2026 оны 11-р сарын 01-ний дотор		Уурхайн дарга, Байгаль орчны ажилтан	
НИЙТ ДҮН					520.0		

Хяналтын хуудас

**Уул уурхайн төслийн байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний хяналтын хуудас**

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтнүүдийн хувийн дугаар	Шинжээч бөглөнө
Дүгнэлт • Шийдвэрийн төсөл • Ололт, амжилттай тал • Дутагдалтай сул тал • Шаардлага	Шинжээч бөглөнө

Нэг. Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, төслийн тухай товч мэдээлэл

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1.Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Эрчим Баян өлгий ХК
	2.Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	210001004
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Нүүрсний олборлолт, борлуулалт
	5.Захирлын нэр,утас,цахим шуудангийн хаяг	Ахмет 99429580
	6.Холбогдох мэргэжилтний нэр,утас,цахим шуудангийн хаяг	Д.Батзул 95452808 D_Batzul@yahoo.com
1.2	1Төслийн нэр	Нүүрст хотгор 1-р давхарга
	2.Төслийн харьяаллын байршил	Увс аймаг Бөхмөрөн сум 2-р баг /Хар алтат/
	3.Төслийн ангилал	Ил уурхай
	4.Төсөл эхэлсэн огноо	2009
	5.Төсөл хэрэгжих хугацаа	30
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	-
	7.Хаалтын дараах зориулалт	-
	8.ТЭЗҮ баталсан огноо	2024
	9.Урьд оны нийт бүтээгдхүүний хэмжээ /дундаж/	55мян/тн
	10.Ажилчдын тоо	16
	11.Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
	12.Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Баруун бүсийн эрчим хүчний цахилгаанд холбогдсон
	• Замын урт, эхлэл төгсгөлийн цэг, чиглэл	Баян-Өлгийгөөс уурхайн чиглэлд 140км
	• Шатахуун түгээгүүрийн тоо	1 /явуулын түгээгч машин/
	• Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ	Агуулах байхгүй
	• Тэслэх дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал	Тэсрэх бодис хэрэглэдэггүй

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДСОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ,ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Мэдээллийн төрөл		Мэдээлэл оруулах багана
2.1	1.Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай		Нүүрс 5696А 30жил 29га
	2.Тусгай зөвшөөрлийн төрөл/химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа		Хамааралгүй
	3.Химийн бодисын агуулахд хийсэн Мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт		Хамааралгүй
	4.Галын дүгнэлтийн огноо дугаар		2025.04.21
	5.Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо баталсан хуулийн этгээд		
	6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо баталсан хуулийн этгээд		2024-01-24
	7.Ус ашиглалтын дүгнэлтийн огноо		2025 онд Хар нуур Ховд голын сав газрын захиргаа
	8.Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний батлагдсан огноо		2026.05 сар
	9.Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1,1.5,1.7,1.9,1.10,1.11 дэх маягтыг хавсаргах		Хавсаргав
	10.Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт /га-р/ Тайлант онд гүйцэтгэсэн	Заагдсан талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгднэ. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 200ш мод тарина.
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	
		Тайлант онд гүйцэтгэсэн	
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэх	
	11.ТХГН-ын тухай хууль,Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс,ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах		Хамааралгүй
	11.Тухайн жилд баримтлах стандартын дугаар • Үндэсний		MNS-888:83

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ,ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, /хэмжээ хэмжих нэгж/	Хамааралгүй
	2. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдлийн үед авах арга хэмжээ - Учруулсан хор уршгийг зайлуулах,бууруулах арга хэмжээ -Хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй
3.2	1. Шатах, тослох материалын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ агуулахд байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	ДТ Масло Бензин А-80өтгөн тос 1тонн, дизель түлш 1тонн Шингэн тос саваар авч хэрэглэнэ. Хамааралгүй
3.3	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ - Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн - Аюултай хог хаягдал	Хатуу хог хаягдал-20 Шингэн хог хаягдал-200кг Хамааралгүй
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	1,100,000 төгрөг

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	15,050,000
	2.Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв	3,460,000
	3.Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	
	4.Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 500ш мод тарина	1,300,000
	5.Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	4,400,000
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	520,000
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1,300,000
	8,Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	100,000
	9.Тухайн жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1,400,000
	10.Осол эрсдлийн төлөвлөгөөний төсөв	1,470,000
	11.Хог хаягдлын төлөвлөгөөний төсөв	1,100,000

Тав. Мета мэдээлэл

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	Төлөвлөгөөний зурагт тусгасан
	Хог хаягдлын цэгийн байршил	Төлөвлөгөөний зурагт тусгасан
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	Үгүй
	Хаягдлын далан	Овоолго
	Химийн бодисын агуулахын байршил	Үгүй
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	Төлөвлөгөөний зурагт тусгасан
	Хяналтын цэгийн байршил	Төлөвлөгөөний зурагт тусгасан
	Тухайн жилд хуулах хөрс	24000м3
	Гадаад, дотоод овоолго	Гадаад овоолготой
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	Үгүй
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	Үгүй
	Гүний худгийн байршил	Төлөвлөгөөний зурагт тусгасан
	Дүйцүүлэн хамгаалал хийх байршил	Төлөвлөгөөний зурагт тусгасан

Зургаа. Тухайн жилийн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээний хяналтын хуудас

Нөлөөллийн ангилал	А тооцсон эсэх	Б Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
1.Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Эвдэх • Доройтуулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
2.Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
3.Амьтан ургамалд үзүүлэх нөлөөлөл • Амьдрах орчинг хуваах • Амьдах орчинг доройтуулах • Амьдрах орчинг Хомсдуулах • Нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
4. Агаарт үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Тоос	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
5.Түүх соёлын дурсгалт эд зүйлс • Хамгаалах • Нүүлгэн шилжүүлэх	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	

**Долоо. Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний
дүн шинжилгээний хяналт**

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А Тоо	Б Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г Дүгнэлт
1.Нөлөөллийг урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	5	тийм	Тийм	
2.Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	12	тийм	тийм	
3.Нөхөн сэргээлтийн арга хэмжээ • Техникийн • Биологийн	Үгүй	үгүй	үгүй	
4.Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	1	тийм	Тийм	
5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	3	тийм	тийм	
6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	1	тийм	Тийм	
7.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	12	тийм	тийм	

**Найм. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний
хяналтын хуудас**

Хяналт шинжилгээний дээж	А Дээж авах цэгийн тоо	Б Дээж авах цэгийн байршил	В Давтамж /удаа/	Г Төсөв төг
1. Хөрс	2	Зурагт тэмдэглэсэн	2	400,000
2. Ус	2	Гүний худаг	2	400,000
3. Ургамал		Мод тарьж ургуулж байна		-
4. Агаар	2	Зураг хавсаргав	2	400,000
5. Амьтан	1			200,000
				1,400,000